



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй
хэлцэл хийх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дох заалт, 91 дүгээр зүйлийн 91.2 дох заалт, Премиум Нэксус ХК (“Компани”)-ийн Дүрмийн 9.4.18 дах заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Голомт Банкнаас авах 24 (хорин дөрвөн) сарын хугацаатай 23,200,000,000 (хорин гурван тэрбум хоёр зуун сая) төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл, Премиум Юнайтэд ХХК-ийн Голомт Банкнаас авах 24 (хорин дөрвөн) сарын хугацаатай 4,000,000,000 (дөрвөн тэрбум) төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл, Сэнтрал Фүүдс ХХК-ийн Голомт Банкнаас авах 36 (гучин зургаан) сарын хугацаатай 1,200,000,000 (нэг тэрбум хоёр зуун сая) төгрөгийн хөрөнгө оруулалтын зээлийн барьцаанд Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд болох Аркадиа Гарден ХХК, Сүлд Итгэл Соёмбо ХХК болон Юу Эм Эс ХХК-ийн эзэмшлийн дор дурдсан хөрөнгүүдийг барьцаалахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - (i) Аркадиа Гарден ХХК-ийн Y-2204127074 болон Y-2204127076 дугаартай аялал жуулчлал, амины орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгүүд,
 - (ii) Юу Эм Эс ХХК-ийн улсын бүртгэлийн Э-2204046147 дугаартай үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад зориулалттай эзэмших эрхийн газар,
 - (iii) Сүлд Итгэл Соёмбо ХХК-ийн улсын бүртгэлийн Э-2204013335 дугаартай худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай эзэмших эрхийн газар.
2. Тогтоолын 1-д дурдсан хөрөнгүүдийг барьцаалахтай холбогдох барьцааны гэрээг байгуулах, гэрээнд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирлын орлогч (Г.Чинзориг)-д, Премиум Юнайтэд ХХК-ийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Премиум Юнайтэд ХХК-ийн Гүйцэтгэх захирал (С.Дашдорж)-д, Сэнтрал Фүүдс ХХК-ийг төлөөлөн гарын үсэг зурах эрхийг Сэнтрал Фүүдс ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Д.Жүгдэрнамжил)-д тус бүр олгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана.)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ДАРГА:



ГАРИ БИОНДО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

А.ГАНХУЯГ

А.ГАНБОЛД

Г.БАТ-ЭРДЭНЭ

Ч.МӨНХЧИМЭГ

Г.ЧИНЗОРИГ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

В.ГАНЗОРИГ